

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн д ансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	11
3.2	Урьдчилж гарсан зардал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Хавсралт	21
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
Тн	Тонн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦЭНГЭЛ ТАНАА

2019.02.25 № 06/216
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/627 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж, ажиллахын тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулж батлуулах, бодлогын удирдамжаар хангах, түүнийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, цэвэр технологийг дэмжих, салбарын санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангах;

2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, байгаль орчны сайн засаглалыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоо, хяналтад тулгуурлан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;
4. Ойн экосистемийн тэнцвэрийг хадгалах, нөөцийн хомсдолыг хязгаарлан зогсоох, ойн санг арвижуулах, нөөцийг иж бүрэн ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох, ойн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;
5. Усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах, газар зохион байгуулалт болон усны талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;
6. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;
7. Аялал жуулчлалын талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;
8. Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэл, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хот, суурины ногоон байгууламжийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны нийт зардал 29,369,104.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 587,382.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн шатанд тогтоосон 2 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	220,733.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	300,000.0	
3	Албан шаардлага өгсөн	1	17,200.0	
	Дүн	4	537,933.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Санхүүгийн тайлангийн залруулга

Төвлөрүүлэх шилжүүлэг 4,398.6 мянган төгрөг, хөрөнгө бэлтгэсэн 148,563.5 мянган төгрөг нийт 152,962.1 мянган төгрөгийг үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансанд давхар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад 152,962.1 мянган төгрөгийн алдааг залруулсан

2.8.1.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт хэрэгжилт

Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрөөс тайлант онд стандартын шаардлагад нийцсэн 31.0 мянган тн сайжруулсан шахмал түлш нийлүүлэх гэрээт ажлын урьдчилгаанд 1,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч гүйцэтгэгч компаниудын ирүүлсэн тайлангаар 6.0 мянган тн шахмал түлш борлуулсан нь гүйцэтгэл 20 хувьд хүрэхгүй байна. Үүнээс нийт 600,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан 2 компани тайлангаа ирүүлээгүйгээс 300,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан Дуулгант Өлзийт ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.8.1.3 Худалдан авалт болон гэрээний биелэлт хэрэгжилт

Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн ажлын албаны батлагдсан төсвөөс 17,200.0 мянган төгрөгөөр автомашин худалдан авсан боловч жолооч нь зам тээврийн осол гаргаж ашиглах боломжгүй болсон байна.

Энэ нь оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх гэрээт ажилд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, аялал жуулчлалын хөтөлбөрт тусгагдсан хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээнд нэмж хуваарилсан 33,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг шалгах шаардлагатай гэж үзлээ.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 32,908,912.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 26,311,320.3 мянган төгрөг буюу 80.0 хувьтай байгаа нь Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн төлөвлөгдсөн ажлууд бүрэн хэрэгжээгүйгээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь shilendans.gov.mn цахим хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ болон бусад мэдээллийг мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж, 3 албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 95.7 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт

Ойжуулалт, ойн арга хэмжээний хөтөлбөрийн батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаанд 81,200.0 мянган төгрөг, аялал жуулчлалын хөтөлбөрийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын гүйцэтгэл 2018 оны 3 дугаар улиралд гарсан боловч 4 дүгээр улиралд нэмж 33,000.0 мянган төгрөг хуваарилан зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Урьдчилж гарсан зардал

3.2.1 Илрүүлэлт

Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 106,533.0 мянган төгрөгийн гэрээт ажлууд нь гэрээний хугацаанд хийгдээгүй, газрын маргаантай асуудлаар ажил зогссон, ажил хүлээн авсан актгүй зэргээс шалтгаалан он дамжин бүртгэгдсэн байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй” байх гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>,381,301,731.87</u>	<u>,817,411,402.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,000.00	1,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,000.00	1,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,000.00	1,000.00
33	АВЛАГА	359,376,998.71	530,227,191.41
33300	Татаас, санхүүжилтийн авлага	46,118,248.29	217,366,579.17
335	Бусад авлага	313,258,750.42	312,860,612.24
3351	Байгууллагаас авах авлага	312,484,279.40	312,176,955.45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	774,471.02	683,656.79
34	УРЬДЧИЛГАА	5,707,238,139.10	7,970,211,603.00
34600	Урьдчилж гарсан зардал	5,694,960,832.10	7,960,346,583.00
3471	Урьдчилгаа тооцоо	12,277,307.00	9,865,020.00
34714	Томилолтын урьдчилгаа	12,277,307.00	9,865,020.00
35	БАРАА МАТЕРИАЛ	312,208,194.31	316,971,608.29
354	Хангамжийн материал	312,208,194.31	316,971,608.29
35410	Бичиг хэргийн материал	13,996,094.40	14,588,147.60
35420	Аж ахуйн материал	288,651,335.25	277,016,085.25
35430	Сэлбэг хэрэгсэл	1,970,600.00	11,838,600.00
35440	Түлш, шатах тослох материал	3,302,000.00	1,433,411.00
35470	Бусад хангамжийн материал	4,288,164.66	12,095,364.44
36	НӨӨЦИЙН БАРАА	2,477,399.75	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,511,587,710.83</u>	<u>4,142,861,787.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,511,587,710.83	4,142,861,787.94
392	Биет хөрөнгө	2,457,982,361.01	3,186,179,788.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,349,381,240.00	1,011,958,613.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	260,244,600.00	397,536,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(201,416,832.22)	(131,443,941.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,818,094,829.02	1,885,080,209.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,462,646,432.96)	(1,629,570,823.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	855,209,563.12	679,769,925.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(725,679,297.68)	(585,762,951.38)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,174,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	137,263,441.00	607,335,441.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,349,004.68)	(222,723,284.48)
393	Биет бус хөрөнгө	53,605,349.82	956,681,999.81
39301	Програм хангамж	22,748,250.00	22,748,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(22,428,250.04)	(22,508,250.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	242,511,400.00	1,169,453,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(189,226,050.14)	(213,011,400.11)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,892,889,442.70</u>	<u>12,960,273,190.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>74,138,004.29</u>	<u>25,292,877.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	74,138,004.29	25,292,877.00
413	Бусад өглөг	74,138,004.29	25,292,877.00
41361	Байгууллагад төлөх өглөг	74,138,004.29	25,292,877.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,818,751,438.41</u>	<u>12,934,980,313.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,818,751,438.41	12,934,980,313.64
511	Засгийн газрын оруулсан капитал	2,954,229,779.25	3,881,171,779.25
51101	Өмч: - төрийн	2,954,229,779.25	3,881,171,779.25
512	Хуримтлагдсан үр дүн	5,809,083,336.99	8,285,678,727.31
51210	Өмнөх үеийн үр дүн	5,663,363,161.79	5,822,536,505.74
51220	Тайлант үеийн үр дүн	145,720,175.20	2,463,142,221.57

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,438,322.17	768,129,807.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,892,889,442.70	12,960,273,190.64

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,444,417,512.45	31,832,246,434.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,253,838.00	435,893,820.16
120	Нийтлэг татварын бус орлого	3,253,838.00	435,893,820.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,253,838.00	430,788,143.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,253,838.00	37,583,689.11
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	393,204,454.00
120009	Бусад орлого	-	5,105,677.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,441,163,674.45	31,396,352,614.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,459,727,468.00	29,554,019,557.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,459,727,468.00	29,554,019,557.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	981,436,206.45	1,842,333,057.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	492,149,206.45	1,842,333,057.17
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,287,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	19,285,108,417.55	29,210,996,676.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,602,682,627.75	18,938,996,993.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,829,850,210.74	12,397,093,862.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,676,382,771.11	1,879,055,164.35
210101	Үндсэн цалин	1,479,554,506.47	1,171,153,530.77
210102	Нэмэгдэл	93,599,381.71	277,067,289.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,533,448.01	193,014,900.00
210104	Урамшуулал	-	84,821,439.00
210105	Гэрээт ажлын хөлс	135,294,816.63	152,998,005.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,934,885.93	224,395,789.51
210201	Тэтгэврийн даатгал	124,509,466.48	157,107,868.05
210202	Тэтгэмжийн даатгал	15,237,962.91	16,829,567.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,467,458.82	13,479,886.62
210204	Ажилгүйдлийн даатгал	4,555,681.56	3,371,324.57
210205	Эрүүл мэндийн даатгал	34,164,316.16	33,607,142.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,485,970.00	68,576,198.95
210301	Гэрэл, цахилгаан	18,744,600.00	20,047,300.00
210302	Түлш, халаалт	29,909,612.00	38,399,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,831,758.00	10,129,098.95
2104	Хангамж, бараа материалын зардал	98,162,569.60	156,830,213.81
210401	Бичиг хэрэг	35,443,579.00	35,918,640.00
210402	Тээвэр, шатахуун	20,825,850.00	21,076,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,193,140.60	45,717,098.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	54,118,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,638,591.00	16,257,804.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,079,980.00
210604	Урсгал засвар	12,638,591.00	13,177,824.00
2107	Томилолт, зочны зардал	42,083,500.00	30,796,900.00
210702	Дотоод албан томилолт	42,083,500.00	30,796,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,987,157,778.41	9,431,065,292.24

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,978,420,358.41	9,413,277,842.24
210803	Даатгалын үйлчилгээ	2,240,400.00	2,240,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	989,220.00	949,490.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	159,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,266,100.00	14,419,560.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	142,700.00	19,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	765,004,144.69	590,116,499.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	352,834,719.00	54,055,163.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,130,320.00	202,706,517.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	386,039,105.69	333,354,819.85
212	ТАТААС	-	3,094,912,500.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	3,094,912,500.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	3,094,912,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	772,832,417.01	3,446,990,631.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180,795,400.00	183,911,694.43
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	180,795,400.00	183,911,694.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,563,878.04	3,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,966,000.00	3,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,697,878.04	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,900,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,473,138.97	3,259,178,936.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,473,138.97	3,259,178,936.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,682,425,789.80	10,271,999,682.33
2200	Дотоод эх үүсвэрээр	8,682,425,789.80	10,271,999,682.33
223001	Бусад хөрөнгө	8,682,425,789.80	10,271,999,682.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	159,309,094.90	2,621,249,758.27
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,588,919.70	158,107,536.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,588,919.70	26,638,641.70
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	131,468,895.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)	(13,588,919.70)	(158,107,536.70)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	145,720,175.20	2,463,142,221.57

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	19,444,228,595.45	31,435,332,289.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,065,921.00	38,979,675.11
120	Нийтлэг татварын бус орлого	3,065,921.00	38,979,675.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,065,921.00	38,979,675.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,065,921.00	38,979,675.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,441,163,674.45	31,396,352,614.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,459,727,468.00	29,554,019,557.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,459,727,468.00	29,554,019,557.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	981,436,206.45	1,842,333,057.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	492,149,206.45	1,842,333,057.17
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,287,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,453,567,996.45	21,026,807,793.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,453,567,996.45	21,026,807,793.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,632,817,331.15	14,267,538,083.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,668,845,491.28	1,808,388,495.36
210101	Үндсэн цалин	1,018,704,184.00	1,135,180,495.36
210102	Нэмэгдэл	386,644,081.27	420,876,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	131,248,199.01	162,930,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	132,249,027.00	89,401,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,737,879.63	209,815,057.00
210201	Тэтгэврийн даатгал	186,737,879.63	141,073,757.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	17,185,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	13,748,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	3,437,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	34,370,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,485,970.00	68,576,198.95
210301	Гэрэл, цахилгаан	18,744,600.00	20,047,300.00
210302	Түлш, халаалт	29,909,612.00	38,399,800.00
210303	Цэвэр, бохир ус	6,831,758.00	10,129,098.95
2104	Хангамж, бараа материалын зардал	96,873,165.06	100,314,578.84
210401	Бичиг хэрэг	31,777,690.00	33,277,600.00
210402	Тээвэр, шатахуун	20,699,900.00	17,455,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,523,575.06	47,924,398.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	872,000.00	1,656,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,359,691.00	18,763,804.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,079,980.00
210604	Урсгал засвар	17,359,691.00	15,683,824.00
2107	Томилолт, зочны зардал	42,470,100.00	32,336,900.00
210702	Дотоод албан томилолт	42,470,100.00	32,336,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,161,801,132.64	11,767,298,123.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,146,564,562.64	11,748,574,071.94
210803	Даатгалын үйлчилгээ	2,240,400.00	2,240,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	989,220.00	949,490.00

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,036,550.00	15,393,162.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	871,400.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	403,243,901.54	262,044,925.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	376,591,581.54	46,874,763.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,652,320.00	215,170,162.00
212	ТАТААС	-	3,094,912,500.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	3,094,912,500.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	3,094,912,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	820,750,665.30	3,664,357,210.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180,795,400.00	183,911,694.43
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	180,795,400.00	183,911,694.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,363,878.04	3,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,966,000.00	3,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,697,878.04	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	551,591,387.26	3,476,545,515.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	551,591,387.26	3,476,545,515.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,990,660,599.00</u>	<u>10,408,524,496.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,990,660,599.00	10,408,524,496.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,990,660,599.00	10,408,524,496.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,990,660,599.00	10,408,524,496.00
223001	Бусад хөрөнгө	8,855,450,934.00	10,259,960,966.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	135,209,665.00	148,563,530.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(8,990,660,599.00)</u>	<u>(10,408,524,496.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000.00

4.6 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,683,631,713.74	8,693,299,815.16
C02	НБББ-ын өөрчлөлт	-	-	(20,268,551.95)	(20,268,551.95)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,663,363,161.79	8,673,031,263.21
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	145,720,175.20	145,720,175.20
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,809,084,336.99	8,818,751,438.41
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,809,084,336.99	8,818,751,438.41
D02	НБББ-ын өөрчлөлт	-	-	13,453,168.75	13,458,168.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,822,536,505.74	8,832,204,607.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	712,691,484.91	-	712,691,484.91
D08	Тайлант үеийн үр дүн	926,942,000.00	-	2,463,142,221.57	3,390,084,221.57
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,881,171,779.25	768,129,807.08	8,285,678,727.31	12,934,980,313.64

4.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,908,912,200.00	26,311,320,295.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,580,912,200.00	16,051,359,329.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,134,805,100.00	12,768,635,135.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,691,505,000.00	1,624,064,122.36
210101	Үндсэн цалин	993,537,000.00	950,856,122.36
210102	Нэмэгдэл	420,876,400.00	420,876,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	187,690,000.00	162,930,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	89,401,600.00	89,401,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	187,618,500.00	187,618,500.00
210201	Тэтгэврийн даатгал	118,877,200.00	118,877,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,185,300.00	17,185,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,748,300.00	13,748,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,437,100.00	3,437,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,370,600.00	34,370,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,576,200.00	68,576,198.95
210301	Гэрэл, цахилгаан	20,047,300.00	20,047,300.00
210302	Түлш, халаалт	38,399,800.00	38,399,800.00
210303	Цэвэр, бохир ус	10,129,100.00	10,129,098.95
2104	Хангамж, бараа материалын зардал	94,337,600.00	91,946,578.84
210401	Бичиг хэрэг	25,219,000.00	24,909,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,474,900.00	17,455,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,826,100.00	47,924,398.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,817,600.00	1,656,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,283,500.00	15,683,824.00
210604	Урсгал засвар	18,283,500.00	15,683,824.00
2107	Томилолт, зочны зардал	24,073,400.00	18,766,400.00
210702	Дотоод албан томилолт	24,073,400.00	18,766,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,030,297,300.00	10,747,204,220.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,006,912,900.00	10,728,480,168.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,207,400.00	2,240,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	990,000.00	949,490.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,000,000.00	15,393,162.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	75,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20113600.00	14775290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,400,000.00	8,290,490.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,713,600.00	6,484,800.00
212	ТАТААС	8,253,100,000.00	3,094,912,500.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох	00.00	3,094,912,500.00

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	татаас		
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	3,094,912,500.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	8,253,100,000.00	
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	8,253,100,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193007100.00	187811694.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	187,687,800.00	183,911,694.43
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	187,687,800.00	183,911,694.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,319,300.00	3,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,319,300.00	3,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,328,000,000.00	10,259,960,966.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,328,000,000.00	10,259,960,966.00
223001	Бусад хөрөнгө	10,328,000,000.00	10,259,960,966.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,908,912,200.00	26,311,320,295.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,908,912,200.00	26,294,840,620.41
131001	Улсын төсвөөс санхүүжих	32,908,912,200.00	26,294,840,620.41
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	16,479,675.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	16,479,675.11
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	1,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	121.00	121.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	100.00	100.00

5 ХАВСРАЛТ

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо: 2019/02/22	Аудитын нэр:	<i>Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	Аудитын код: САГ-2019/163/ СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Сайжруулсан шахмал түлш нийлүүлэх гэрээт ажлыг гүйцэтгээгүй Дуулгант өлзийт оргил ХХК-д олгосон санхүүжилт	300,000.0	Төлбөрийн акт			Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч	Ц.Цэнгэл О.Гантулга Д.Гүндсам буу О.Дуламсүрэн
2	Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн ажлын албаны батлагдсан төсвөөс автомашин худалдан авсан боловч жолооч нь зам тээврийн осол гаргаж ашиглах боломжгүй болсон байна	17,200.0	Албан шаардлага			Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч	Ц.Цэнгэл О.Гантулга Д.Гүндсам буу О.Дуламсүрэн
3	Хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан.	114,200.0	Зөвлөмж			Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч	Ц.Цэнгэл О.Гантулга Д.Гүндсам буу О.Дуламсүрэн
4	Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй гэрээт ажлууд нь гэрээний хугацаанд хийгдээгүй, газрын маргаантай асуудлаар ажил зогссон, ажил хүлээн авсан актгүй зэргээс шалтгаалан он дамжин бүртгэгдсэн байна.	106,533.0	Зөвлөмж			Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч	Ц.Цэнгэл О.Гантулга Д.Гүндсам буу О.Дуламсүрэн
Нийт		537,933.0					

